

СУРГАЛТЫН ТАЙЛАН

Монголын Барилгын Инженерүүдийн Холбоо нь Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль – Барилга Архитектурын Сургуулийн Автодескийн эрх бүхий сургалтын төвтэй хамтран Зураг төсөл, тоо хэмжээг төлөвлөх үйл явцыг дэвшилтэт технологийн (Autodesk Revit программ) тусламжтайгаар гүйцэтгэх ур чадварыг эзэмшүүлэх замаар барилга, дэд бүтцийн салбарт Autodesk Revit программыг өргөн хэрэглээнд нэвтрүүлэх зорилгоор Revit-MEP анхан дунд шатны сургалтыг Барилга Архитектурын Сургуулийн лабораторид 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс 10 дугаар сарын 09-ний өдрүүдэд зохион байгуулсан.

Уг сургалтад хамрагдсанаар Инженерчлэлийн орчин үеийн, дэвшилтэт программ хангамжийг эзэмших, Ажлын бүтээмж, нарийвчлал сайжрах, Механик үйлдлүүдийг автоматжуулж, алдаа дутагдлыг багасгах, Revit дээр төсөл байгуулах 1.7:2.1 ба 3.1: 2.2: 2.3: 2.4 системийг 2D-3D хэмжээст үүсгэж ажлын зураг, тайлан бэлтгэх зэргийг сурсан.

ТАНИЛЦСАН:

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”

ОНӨТҮГ-ЫН ДАРГА

Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН БИЧСЭН:




“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”

ОНӨТҮГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.МӨНГӨНХУЯГ

Хавсралт

Сургалтын явцад Revit Мер программыг ашиглан тухайн барилгын халаалт, агаар сэлгэлтийн систем болон цэвэр бохир усны төлөвлөлтийг гүйцэтгэв.





ШУТИС-Барилга Архитектурын Сургууль Автодескийн эрх бүхий сургалтын төв

Revit програмын сургалтын хөтөлбөр

1. Revit-Architecture (анхан дунд шат) сургалт: /5 хоног, 4кр, 400000₮/

Сургалтын зорилго: Суралцагчийг бүрэн хэмжээний 3 хэмжээст архитектурын төслийг боловсруулж ажлын зураг бэлтгэж гаргах арга барилд сургах

Сургалтын агуулга:

- BIM ийн үндсэн ойлголт ба Revit програмын тухай
- Revit Architecture програмын хэрэглэгчийн интерфэйс
- Үндсэн зурах ба засварлах командуудын хэрэглээ
- Тэнхлэг, түвшин татах
- Хана, хаалга, цонх бүхий 3 хэмжээст барилгын загвар үүсгэх
- Барилгын загварт шал, тааз, дээвэр нэмэх
- Бэлэн загварын болон хэрэглэгчийн хүссэн загвараар шат үүсгэх
- Тавилга, тоног төхөөрөмж зэрэг загварын хэрэгслүүдийг төсөлд нэмэх
- Текст, хэмжээс, детал, шошго, хүснэгттэй хуудас бэлтгэх
- Ажлын зураг бэлтгэх

2. Revit-Structure (анхан дунд шат) сургалт: /5 хоног, 4кр, 400000₮/

Сургалтын зорилго: Барилгын зураг төслийг загварчлах, ажлын зураг, бичиг баримт гаргах чадвартай болгох

Сургалтын агуулга:

- Барилгын төслийн загварчлал, арга зүй, Revit програмын интерфэйсийн хэрэгслүүдийг ашиглах
- Харах хэлбэрүүдийг ашиглах, түвшин болон тэнхлэгтэй ажиллах
- CAD болон Revit Architecture-н зураг холбох, ашиглах
- Бүтээцийн элементүүд байгуулах
- Дамнуруу болон дамнуруун системтэй ажиллах, рам байгуулах,
- Төмөр бетон бүтээцтэй ажиллах, арматурчлах
- Хосоглол хийх, CAD програмтай харилцан ажиллах
- Ажлын зураг бэлтгэх, тайлбар тэмдэглэгээ оруулах
- Ажлын төлөвлөгөө хийх, материалын түүвэр гаргах

3. Revit-MEP (анхан дунд шат) сургалт: /5 хоног, 4кр, 400000₮/

Сургалтын зорилго: Revit MEP-ийн орчинд чөлөөтэй ажиллаж, сантехник, цахилгааны зураг төслийг боловсруулах чадвартай болно.

Сургалтын агуулга:

- BIM-ийн тухай, Revit MEP програмыг хэрэглэх хэрэгцээ, шаардлага
- Revit MEP програмыг суулгах, суралцах болон хэрэглэх эрхийн тухай
- Програмын интерфэйстэй танилцаж, элемент үүсгэх болон засварлах үндсэн хэрэгслийг хэрэглэх,
- Файлын өгөгдлийг удирдах, олон төрлийн харагдац үүсгэх, харагдацтай ажиллах, шүүлтүүр болон харагдацын загвар үүсгэх
- CAD болон Revit дээр зурсан архитектур, бүтээцийн зургийг татаж оруулах, үүнээс шаардлагатай элементийг авч ашиглах,
- Архитектурын зурагтай холбогдсоны дараа орон зай, зооныг үүсгэж дулааны ба хөргөлтийн ачааллын тооцоо хийж, тайлан бэлтгэх
- Цахилгаан, халаалт, агаар сэлгэлт, цэвэр ус, бохирын системийг үүсгэж, ажлын зураг тайлан бэлтгэх

4. Revit (ахисан шат) сургалт: /2 хоног, 2кр, 200000₮/

Сургалтын зорилго: Бүрэлдэхүүн файл буюу family үүсгэх, Өөрийн хүссэн огтлол бүхий бүтээцийн элемент үүсгэх, ашиглах чадвартай болох, багаар ажиллах

Сургалтын агуулга:

- Нийлмэл огтлолтой багана, хавтан, рам гэх мэт үүсгэх, хувиргах
- Татангатай ажиллах
- Нэг төсөл дээр багаар ажиллах

Сургалт явуулах өрөө: ШУТИС-II байр, БАС-ийн 2-403 тоот лаборатори

Хичээллэх цаг: 9:30-17:00

Сертификат: Autodesk-ийн сертификат эсвэл БИХ-ны харгалзах кредит тооцох сертификат

Ном, сургалтын материал дагалдана

Хөтөлбөр гаргасан: Н.Саранчимэг /88100089/